



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ОНХС	Орон нутгийн хөрөнгө оруулалтын сан
БШУ	Боловсрол шинжлэх ухаан

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022. 02. 25 № СЭА-2022/111-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	87,563,381.70	95,824,953.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	1,127,081.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	1,127,081.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,563,381.70	94,697,872.70
35100	Түүхий эд материал	0.00	2,779,600.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	2,329,600.00
35130	Эм боох материал	0.00	450,000.00
35400	Хангамжийн материал	87,563,381.70	91,918,272.70
35410	Бичиг хэргийн материал	0.00	165,000.00
35420	Аж ахуйн материал	69,375,481.70	69,375,481.70
35430	Сэлбэг хэрэгсэл	120,000.00	120,000.00
35460	Хүнсний материал	0.00	1,177,700.00
35470	Бусад хангамжийн материал	18,067,900.00	21,080,091.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	313,820,455.02	317,477,723.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	313,820,455.02	317,477,723.69
39200	Биет хөрөнгө	299,709,205.04	303,366,473.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	320,757,407.00	320,757,407.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(122,756,421.84)	(130,431,741.39)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	69,103,623.00	72,463,623.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,079,201.36)	(28,845,254.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,196,384.00	37,196,384.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,874,744.40)	(16,817,385.26)
39209	Зам, гүүрийн байгууламж	48,138,800.10	48,138,800.10
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,190,150.10)	(2,649,525.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,258,400.00	8,258,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,882,744.86)	(6,742,087.54)
39217	Ном	2,037,853.50	2,037,853.50
39300	Биет бус хөрөнгө	14,111,249.98	14,111,249.98
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(218,750.02)	(218,750.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,080,000.00	14,080,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	401,383,836.72	413,302,677.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	401,383,836.72	413,302,677.39
51	Засгийн газрын хувь оролцоо	401,383,836.72	413,302,677.39
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	215,688,467.50	215,688,467.50
51200	Хуримтлагдсан үр дүн	4,070,281.02	15,989,121.69
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,273,472.06)	4,070,281.02
51220	Тайлант үеийн үр дүн	9,343,753.08	11,918,840.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	181,625,088.20	181,625,088.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	401,383,836.72	413,302,677.39

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	400,992,574.00	448,673,346.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,921,330.00	21,248,746.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,921,330.00	21,248,746.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,877,750.00	19,860,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,043,580.00	1,388,746.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,071,244.00	427,424,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	355,626,200.00	378,716,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	355,626,200.00	378,716,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	1,425,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	158,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	1,267,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,945,044.00	47,283,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,945,044.00	47,283,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	391,648,820.92	436,754,505.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,648,820.92	436,754,505.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,890,347.92	404,817,096.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,579,472.00	275,815,550.00
210101	Үндсэн цалин	225,229,699.28	208,710,980.00
210102	Нэмэгдэл	13,243,087.72	46,748,608.00
210104	Урамшуулал	20,106,685.00	20,355,962.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,360,407.00	35,667,743.00
210201	Тэтгэврийн даатгал	22,873,437.00	25,666,780.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,630,695.00	2,229,352.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,097,836.00	1,955,803.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,851.00	435,335.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,244,588.00	5,380,473.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,115,844.00	46,453,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,217,944.00	3,195,848.00
210302	Түлш, халаалт	25,423,200.00	42,740,252.00
210303	Цэвэр, бохир ус	474,700.00	517,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,377,680.00	6,164,472.00
210401	Бичиг хэрэг	131,300.00	315,000.00
210402	Тээвэр, шатахуун	661,500.00	1,111,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	411,300.00	526,367.00
210404	Ном, хэвлэл	95,500.00	165,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,978,080.00	770,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,000.00	3,276,005.00
2105	Нормативт зардал	19,673,930.00	17,938,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,700.00	105,200.00
210502	Хоол, хүнс	19,028,130.00	17,380,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	562,100.00	452,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,466,800.00	1,596,600.00
210604	Урсгал засвар	1,466,800.00	1,596,600.00

2107	Томилолт, зочны зардал	134,100.00	168,600.00
210702	Дотоод албан томилолт	134,100.00	168,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,724,000.00	1,231,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	634,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	597,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,458,114.92	19,780,231.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	641,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,805,400.00	2,077,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,011,714.92	17,702,731.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,758,473.00	31,937,409.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,758,473.00	31,937,409.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,758,473.00	31,937,409.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,343,753.08	11,918,840.67
230001	Эргэж төлөгдөх зээл	0.00	0.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	0.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	0.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	0.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	9,343,753.08	11,918,840.67
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	386,071,244.00	427,424,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,071,244.00	427,424,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	355,626,200.00	378,716,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	355,626,200.00	378,716,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	1,425,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	158,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	1,267,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,945,044.00	47,283,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,945,044.00	47,283,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	380,971,244.00	425,924,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,971,244.00	425,924,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,212,771.00	393,987,191.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,252,520.00	276,942,616.00
210101	Үндсэн цалин	224,902,747.28	209,838,046.00
210102	Нэмэгдэл	13,243,087.72	46,748,608.00
210104	Урамшуулал	20,106,685.00	20,355,962.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,497,307.00	35,667,758.00
210201	Тэтгэврийн даатгал	23,010,337.00	25,453,189.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,404,909.00	2,442,943.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,323,622.00	1,920,757.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,851.00	470,397.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,244,588.00	5,380,472.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,115,844.00	46,453,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,217,944.00	3,195,848.00
210302	Түлш, халаалт	25,423,200.00	42,740,252.00
210303	Цэвэр, бохир ус	474,700.00	517,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,491,000.00	6,046,717.00
210401	Бичиг хэрэг	131,300.00	165,000.00
210402	Тээвэр, шатахуун	661,500.00	914,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	106,300.00	526,367.00
210404	Ном, хэвлэл	95,500.00	330,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,960,000.00	608,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,536,400.00	3,502,850.00
2105	Нормативт зардал	17,509,800.00	23,219,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,700.00	555,200.00
210502	Хоол, хүнс	16,545,000.00	18,558,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	881,100.00	4,106,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,466,800.00	1,831,600.00

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	200,000.00
210604	Урсгал засвар	1,466,800.00	1,631,600.00
2107	Томилолт, зочны зардал	134,100.00	168,600.00
210702	Дотоод албан томилолт	134,100.00	168,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,724,000.00	1,231,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	634,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	597,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,021,400.00	2,424,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	946,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,075,400.00	2,424,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,758,473.00	31,937,409.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,758,473.00	31,937,409.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,758,473.00	31,937,409.00
213504	Хөрөнгийн	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,100,000.00	1,500,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,100,000.00	1,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,100,000.00	1,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,100,000.00	1,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,100,000.00	1,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,100,000.00)	(1,500,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	4,070,281.02	401,383,836.72
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	4,070,281.02	401,383,836.72
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	4,070,281.02	401,383,836.72
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	11,918,840.67	11,918,840.67
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	15,989,121.69	413,302,677.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	425,999,100.00	425,999,100.00		100.00%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,999,100.00	424,499,100.00	74,500.00	99.65%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,999,100.00	392,561,691.00	32,011,909.00	92.15%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,393,000.00	276,942,616.00	16,450,384.00	94.39%
210101	Үндсэн цалин	211,676,900.00	209,838,046.00	1,838,854.00	99.13%
210102	Нэмэгдэл	61,358,400.00	46,748,608.00	14,609,792.00	76.19%
210104	Урамшуулал	20,357,700.00	20,355,962.00	1,738.00	99.99%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,215,600.00	35,667,758.00	5,547,842.00	86.54%
210201	Тэтгэврийн даатгал	28,514,300.00	25,453,189.00	3,061,111.00	89.26%
210202	Тэтгэмжийн даатгал	3,175,300.00	2,442,943.00	732,357.00	76.94%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,540,300.00	1,920,757.00	619,543.00	75.61%
210204	Ажилгүйдлийн даатгал	635,100.00	470,397.00	164,703.00	74.07%
210205	Эрүүл мэндийн даатгал	6,350,600.00	5,380,472.00	970,128.00	84.72%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,453,900.00	46,453,900.00	0	100.00%
210301	Гэрэл, цахилгаан	8,640,900.00	3,195,848.00	5,445,052.00	36.99%
210302	Түлш, халаалт	37,295,200.00	42,740,252.00	-5,445,052.00	114.60%
210303	Цэвэр, бохир ус	517,800.00	517,800.00	0	100.00%
2104	Хангамж, бараа материалын зардал	4,622,000.00	4,621,217.00	783.00	99.98%
210401	Бичиг хэрэг	165,000.00	165,000.00	0	100.00%
210402	Тээвэр, шатахуун	914,500.00	914,500.00	0	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,013,600.00	526,367.00	487,233.00	51.93%
210404	Ном, хэвлэл	120,000.00	330,000.00	-210,000.00	275.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,131,900.00	450,000.00	523,900.00	39.76%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,277,000.00	2,235,350.00	-958,350.00	175.05%
2105	Нормативт зардал	32,783,500.00	23,219,900.00	9,563,600.00	70.83%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	555,200.00	555,200.00	0	100.00%
210502	Хоол, хүнс	28,121,400.00	18,558,150.00	9,563,250.00	65.99%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,106,900.00	4,106,550.00	350	99.99%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,331,600.00	1,831,600.00	1,500,000.00	54.98%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,700,000.00	200,000.00	1,500,000.00	11.76%
210604	Урсгал засвар	1,631,600.00	1,631,600.00	0	100.00%
2107	Томилолт, зочны зардал	168,600.00	168,600.00	0	100.00%
210702	Дотоод албан томилолт	168,600.00	168,600.00	0	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,606,300.00	1,231,500.00	374,800.00	76.67%

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	634,300.00	634,300.00	0	100.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	597,200.00	374,800.00	61.44%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,424,600.00	2,424,600.00	0	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,424,600.00	2,424,600.00	0	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	31,937,409.00	-	31,937,409.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	31,937,409.00	-	31,937,409.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	31,937,409.00	31,937,409.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	31,937,409.00	31,937,409.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	1,500,000.00	-1,500,000.00	
	Дотоод эх үүсвэрээр	0	1,500,000.00	-1,500,000.00	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	425,999,100.00	425,999,100.00	0.00	100.00%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	378,716,000.00	378,716,000.00	0	100.00%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	378,716,000.00	378,716,000.00	0	100.00%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,283,100.00	47,283,100.00	0	100.00%
320001	Орон нутгийн төсвөөс	47,283,100.00	47,283,100.00	0	100.00%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	254	254	0	100.00%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00%
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0	100.00%
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	0	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	15	15	0	100.00%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	203	203	0	100.00%
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	203	203	0	100.00%
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	203	203	0	100.00%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25	0	100.00%
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	25	25	0	100.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,425,500.00	-1,425,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,425,500.00	-1,425,500.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,425,500.00	-1,425,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		0.00	0.00
210101	Үндсэн цалин			0.00
210102	Нэмэгдэл			0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			0.00
210104	Урамшуулал			0.00
210105	Гэрээт ажлын хөлс			0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		0.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал			0.00
210202	Тэтгэмжийн даатгал			0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			0.00
210204	Ажилгүйдлийн даатгал			0.00
210205	Эрүүл мэндийн даатгал			0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		0.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан			0.00
210302	Түлш, халаалт			0.00
210303	Цэвэр, бохир ус			0.00
210304	Байрны түрээс			0.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,425,500.00	-1,425,500.0
210401	Бичиг хэрэг			0.00
210402	Тээвэр, шатахуун			0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			0.00
210404	Ном, хэвлэл			0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		158,000.00	-158,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,267,500.00	-1,267,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,425,500.00	-1,425,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,425,500.00	-1,425,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж			0.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		158,000.00	-158,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,267,500.00	-1,267,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн /Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Б.Батцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Бага насны хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад байгууллага, багш, эцэг эх, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,916.4 мянган 391,648.8 төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,741.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,918.8 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		1,127.0	1,127.0

Бараа материал	87,563.4	94,697.9	7,134.5
Үндсэн хөрөнгө	313,820.4	317,477.7	3,657.3
Нийт хөрөнгө	401,383.8	413,302.6	11,918.8
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	401,383.8	413,302.6	11,918.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	401,383.8	413,302.6	11,918.8

Авлага дансны үлдэгдэл 1,127.0 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ыг илүү төлснөөс шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 7,134.5 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 164.5 мянган төгрөгийн, Жайка олон улсын байгууллагаас 73.6 мянган төгрөгийн, БСШУЯ-с 450.6 мянган төгрөгийн, Ерөө сумын ЗДТГ-с 700.0 мянган төгрөгийн ариутгалын бодис, нэг удаагийн хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 31,287.1 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 25,541.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд /анхны өртгөөр/ 21,360.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 1,500.0 мянган төгрөгийн принтер худалдан авсан, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас 1,860.0 мянган төгрөгийн ус цэвэршүүлэгч үнэ төлбөргүйгээр шилжин ирж, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 18,000.0 мянган төгрөгийн хүүхдийн ор нийлүүлэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 413,302.6 мянган төгрөг болж 11,918.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 47,680.8 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хөрөнгө нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 45,105.7 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн нь түлш халаалтын зардал өссөн нь голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 511,199.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа нь танхим болон танхимын бус үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 456,694.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 426,178.3 мянган төгрөгийг улсын төсвөөс *тусгай зориулалтын шилжүүлгээр*, 30,515.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 378,716.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 47,283.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 425,999.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 394,061.7 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 31,937.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 394,061.7 мянган төгрөг буюу 86.3 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 21,998.2 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 9,563.3 мянган төгрөгөөр, аудит баталгаажуулалтын зардал 375.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 158.0 мянган төгрөг, Ерөө сумын ЗДТГ-с 1,267.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.”* гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь *“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%”* гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт *“Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”*-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.7.3. Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 27,326.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 21 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх *“... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай”* гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 82 мэдээллийг бүрэн оруулж, 60 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгт 456,694.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 394,061.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 13.7 хувиар хэмнэж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,514.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,127.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 702.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 акт тогтоож, 1,127.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 18,558.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд санхүүгийн тайланд 1,127.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг авлагыг тусгаагүй байсныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Арга зүйч Д.Түвшинбаярт орон нутагт ажилласны нэмэгдлийг 15 хувиар тооцон 80.8 мянган төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад “*боловсролын, сургалтын байгууллагын арга зүйн мэргэжилтэн-10 хувь*” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох,

2. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас ажилласан цагийн хөлсийг буруу тооцож, туслах багш Л.Батчимэгт 142.9 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Нягтлан бодогч Р.Дариймаад ажил хавсран гүйцэтгэж буй цалингаас МНБ-ын нэмэгдэлд 478.6 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл*”

болно” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 АЛБАН ШААРДЛАГА

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,127.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Шилэн дансны цахим хуудсанд 60 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг огт мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 **Илрүүлэлт:** Тайлант онд 18,558.2 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 **Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

1.2 Цалингийн данстай холбоотой асуудал

1.3.1 **Илрүүлэлт:** НД тайланд багш Д.Бармаагийн хүүхдээ асрах чөлөөтэй байгаа үеийн 2 сарын цалинг тайлагнаагүй байгаа нь НДШ-ийн акт, өр төлбөр үүсэж болзошгүй байна.

1.3.2 **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул 2022 оны 2-р улиралд багтаан холбогдох байгууллагуудтай дахин тооцоо нийлж, тулган баталгаажуулах.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг	6	21,514.6	1	1,127.0	2	702.3	2	1,127.0	1	18,558.2

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.